



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2011 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийн 7.15 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шилдэг залуу эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Уг журам батлагдсантай холбогдуулан Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2001 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 54 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА



Д.БАТТУЛГА

00559

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын
даргын 2011 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн
146 дугаар захирамжийн хавсралт

**ШИЛДЭГ ЗАЛУУ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН,
СУДЛААЧДАД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
НЭРЭМЖИТ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Судалгаа шинжилгээний бүтээл туурвилаараа дэлхийн болон эх орныхоо шинжлэх ухааны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан, авъяаслаг залуу судлаачдыг хөхиүлэн дэмжих, шинжлэх ухаанд залуу үеийг татан оролцуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналыг жил тутам шинжлэх ухааны салбарын 3 хүртэлх ажилтанд олгоно.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээл нь онол - арга зүйн түвшин, хэрэглээний өгөөжөөрөө тэргүүлж шинжлэх ухааны хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан 35 хүртэлх насны Монгол Улсын иргэнийг шагнана.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал нь Ерөнхийлөгчийн өргөмжлөл, 2 000 000 (хоёр сая) төгрөгийн дагалдах мөнгөн урамшуулал байх бөгөөд жил бүр Бүгд Найрамдах Улс тунхагласны баярыг тохиолдуулан Төрийн ордонд гардуулна.

Хоёр. Нэр дэвшүүлэх, шалгаруулах

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналд шалгаруулахаар эрдэм шинжилгээний байгууллага (эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, их, дээд сургууль) нэр дэвшүүлж, нэр дэвшигчийн бичиг баримтыг жил бүрийн 10 дугаар сарын 20-ний дотор Шинжлэх ухааны Академийн Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ.

2. Нэр дэвшигчийн судалгааны ажлын үр дүн, гаргасан нээлт, шинэ санаа, дүгнэлт, үзэл баримтлал, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр нь товч тодорхой, тооцоо, баримтаар нотлогдсон байна.

3. Нэр дэвшигчийн бичиг баримт нь үнэн зөв бөгөөд баталгаажсан, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн, дотоод, гадаадын нэр хүнд бүхий эрдэм шинжилгээний бичиг, сэтгүүл зэрэгт хэвлэгдсэн, ишлэл авсан, шинэ бүтээлийн патент, зохиогчийн эрх хамгаалсан, өргөдөл, тодорхойлолт зэрэг нь санаачилга гаргагчийн гарын үсэг, тамга тэмдэгтэй байна.

4. Шинжлэх ухааны Академийн Тэргүүлэгчдийн газар 3 хүртэл нэр дэвшигчийг шалгаруулж, энэ журамд заасан бүрдүүлэх бичиг баримтыг 11 дүгээр сарын 10-ны дотор албан тоотоор Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ.

5. Ерөнхийлөгчийн Тамгын газар бүрдүүлбэл зохих баримт бичгүүдийг хянаж, энэ журмын шаардлагад нийцсэн нэр дэвшигчийн талаар санал боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулна. Шаардлагатай гэж үзвэл Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжаар шинжээчийн хэсэг томилон ажиллуулж, дүгнэлт гаргуулж болно.

6. Баримт бичгийн бүрдэл дутуу, журамд заасан хугацаанаас хожимдуулж ирүүлсэн материалыг шалгаруулалтад оруулахгүйгээр нэр дэвшүүлсэн газарт буюу зохиогчид буцаана.

7. Монгол Улсын Ерөнхийлөгч шагналд нэр дэвшигчдийн талаарх Тамгын газрын саналтай танилцаад шилдэг залуу эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох тухай Зарлиг гаргана.

8. Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал хүртсэн бүтээлийн тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын архивт хадгална.

Гурав. Бүрдүүлэх бичиг баримт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт дараах бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд:

- 1) ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэл, тогтоол;
- 2) Хүрээлэн, төв, их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын протокол, тогтоол;
- 3) Нэр дэвшигчийн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (баталгаажсан);

- 4) Шагналд нэрийг нь дэвшүүлж байгаа судалгааны ажлын товч танилцуулга, гарсан үр дүн (1-2 нүүр);
- 5) Дэвшүүлж буй бүтээлд ШУА-аас томилсон хоёр эрдэмтний шүүмж;
- 6) Голлох бүтээлээс гадаад, дотоодод ишлэл авсан тухай баримт;
- 7) Бүтээл нь үйлдвэрлэлд нэвтэрсэн бол тухайн үйлдвэр, аж ахуйн газрын тодорхойлолт;
- 8) Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт;
- 9) Нэр дэвшигчийн анкет (1 дүгээр маягтаар);

---oOo---